

Жамсранжавын Баярсайхан[✉]

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Баясгалант уулын буган хөшөө

Хураангуй. Архангай аймгийн Өгий нуур сумын нутаг Өгий нуурын сав газарт орших Баясгалант уулын өвөрт буй Ооромбо гэгээний дээд хийдийн туурь дээр буй хугархай буган хөшөөг анх удаа бүрэн хэмжээгээр баримтжуулж, уг хөшөөнд дүрслэгдсэн бугын толгойн толт бүхий чинжаал хутга болон бамбайн дүрслэлийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзлээ.

Түлхүүр үг: Хүрлийн үе, буган хөшөө, толтдоо бугын толгойн дүртэй чинжаал

Bayarsaikhan Jamsranjav[✉]

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

Deer Stone at the Bayasgalant Mountain

Abstract. A fragmented deer stone discovered at the site of the Upper Monastery of Oorombo Gegeen, situated at the foot of Bayasgalant Mountain in the Orkhon River basin, Ögii Nuur soum, Arkhangai Province, was comprehensively recorded for the first time. Furthermore, detailed analyses were conducted on the carved motifs of the stele, with particular attention to the depictions of a dagger with a deer-head pommel and a shield.

Keywords: Bronze age, deer stone, dagger with deer-head pommel

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Хархорум хотыг сэргээн байгуулах тухай” 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг, УИХ-ын Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолыг үндэслэн, Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах” тухай хуулийн тавдугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-д заасны дагуу ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс томилогдсон баг 2025 оны 4-5 дугаар сард Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Онгоцон хөндий (27,744 га) Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт орших Элсэн тал (4,800 га), Өгий нуур (2,456 га) нэртэй нийт гурван талбайд археологийн нарийвчилсан хайгуул судалгаа хийсэн билээ (Эрдэнэ-Очир нар, 2025). Уг судалгааны хүрээнд дээр дурдсан талбайн дотор буй дурсгалуудаас гадна талбайн гадна буй зарим дурсгалуудыг нарийвчлан бүртгэн баримтжуулсан юм.

Эдгээрийн нэг нь энэхүү бэсрэг өгүүллээр дамжуулан судалгааны эргэлтэд оруулж буй Баясгалан хайрхны буган хөшөө юм. Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг Өгий нуурын ар биед Баясгалант уулын өвөрт Ооромбо гэгээний дээд хүрээ хэмээх эртний сүмийн нуранги туурь, янз бүрийн хэлбэр, хэмжээтэй чулуун сууриуд бий. Аман түүхийн мэдээгээр бол энэхүү сүм хийдийг 1840-өөд оны эхэн хагаст барьж байгуулсан бөгөөд 1937 оны их хэлмэгдүүлэлтийн үеэс эзэнгүй болж, устан үгүй болсон аж (Монголын Урлагийн Зөвлөл 2025). Энэхүү туурийн төв хэсэгт зэрэгцээ гурван дөрвөлжин чулуун суурь бий. Эдгээрийн хамгийн баруун талын дөрвөлжин суурийн баруун талд нэгэн хугархай буган хөшөө босоо байдалтай байна (Зураг 1-2). Энэхүү буган хөшөөг хэзээ, хаанаас өнөөгийн энэ байрлалд авчирч босгосныг тогтоох хангалттай мэдээлэл олдсонгүй. Миний бодоход ойролцоох газраас зөөвөрлөж авчирсан бололтой. Уг буган хөшөөг 2015 оны Түүх, соёлын

үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын тайланд бүртгэсэн боловч тодорхойлолтыг бүрэн бус, мөн зарим дүрслэлүүдийг орхигдуулж, буруу таньсан аж. Үүнээс өөр энэ дурсгалын талаар хэвлэгдэж нийтлэгдсэн зүйлгүй. Тиймээс энэхүү гайхалтай дурсгалыг шинжлэх ухааны эргэлтэд оруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тодорхойлолт: Уг буган хөшөөг бор шаргал гадаргуутай, цайвар саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд хөшөөний дунд хэсгээр хугарч, хугарсан дээд хэсэг үгүй болжээ. Баттай бус аман мэдээгээр энэхүү хугарсан дээд хэсгийг шинэ үеийн оршуулгын хөшөө болгон зөөсөн гэх боловч хэзээ, хаашаа зөөсөн талаар тодорхой мэдээлэл олж чадсангүй. Хөшөөний өндөр 71 см өндөр, өргөн 20 см, зузаан 81 см. Хөшөөний дээд хэсэг хугарч алга болсноос шалтгаалан чухам аль тал нь нүүрэн тал болохыг тогтоох боломж хомс болжээ. Хэдий тийм боловч буган хөшөөний дүрслэлийн ерөнхий зүй тогтлоор авч үзвэл өдгөө баруун тийш харж буй нарийн тал нь нүүрэн тал бололтой. Тиймээс энэ талаас эхлэн дүрслэлийг нар зөв тойруулан тодорхойлов. Миний нүүрэн тал хэмээн багцаалж буй уг нарийн талд өдгөө хөшөөний орой өөд цувруулан дүрсэлсэн гурван согооны дүрс тодорхой харагдаж буйгаас хамгийн дээд талын согооны толгой хэсгээр хугарч үгүй болжээ. Хөшөөний баруун хажуу талд (өдгөө хойд зүг рүү харсан тал) гурван том буга, 2 согоо, 2 илий, нэг жижиг зоргол, нум, саадаг, бугын толгойн дүрстэй толт бүхий урт чинжаал зэргийг сийлжээ. Мөн тал хэсэг нь хугархай хэсэгтэй хамт алга болсон тахирдуу эд зүйлийн дүрслэл буйг ажиглахад хутганы дүрс бололтой. Гурван том бугыг хийсвэр байдлаар дүрсэлсэн бөгөөд дээд талын хоёр бугын толгой, цээжин хэсгээс урагш дүрслэлүүд нөгөө хугархайтай хамт үгүй болсон. Уг хөшөөн дээрх согоо, илийнүүд бүгд бодит байдлаар дүрслэгдсэн төдийгүй хэмжээний хувьд бугын хийсвэр дүрсүүдээс маш жижиг. Харин бидний ар тал хэмээн багцаалж буй нарийн талд ямар нэгэн дүрслэлгүй. Энэ тал нь бусад талуудыг бодвол засаж янзлаагүй, байгалийн чигээрээ арзгар гадаргуутай буйгаас харахад анхнаасаа дүрслэл сийлээгүй бололтой. Зүүн хажуу талд (өдгөө урд зүг рүү харсан тал) гурван буга, нэг согоо, тагнай хээтэй бамбайг тус тус сийлжээ. Бугуудыг бодит бус шувуу мэт урт хошуутай хийсвэрлэн дүрсэлсэн бөгөөд доод талын бугыг тухайн орон зайд нь таацуулан цээжнээс урагш таллан дүрсэлжээ. Дээд талын хоёр бугын хошуу, толгой хэсэг нь хугарсан хэсэгтэй хамт алга болсон бол дөрөв дэх бугын зөвхөн хойд хөлийн дүрслэл хадгалагдаж үлдсэн байна. Мөн доод талын бугын хошууны дээд талд нэг жижиг согоо, доод талд нь тагнай хээтэй бамбайн дүрслэл бий (Зураг 3).

Дүрслэлийн онцлог: Уг буган хөшөө нь хэдийгээр тал хэсэг нь хугарч алга болсон ч өдгөө хадгалагдаж үлдсэн хэсэгтээ чухал мэдээллийг агуулж үлджээ. Хөшөөний ихэнх дүрслэлүүд нь буган хөшөөний соёлын хүрээнд нийтлэг тохиолдох дүрслэлүүд боловч үүнээс онцлон авч үзүүштэй нэгэн дүрслэлийн тухай тодруулан авч үзье. Энэ бол хөшөөнд дүрслэгдсэн иш дээрээ уулан хээтэй, толтдоо бугын толгойн дүрстэй, чагтан балтагтай, хуйтай урт чинжаал юм. Уг чинжаал нь 59 см урт, үүнээс бугын толгойтой ишний урт нь 25 см. Иш бариулыг уулан хээгээр чимжээ. Буган хөшөөний соёлд толтдоо амьтны толгойн дүрслэлтэй чинжаалын дүрслэл одоогоор 11 буйг бүртгэн баримтжуулжээ. Эдгээрийн хоёр нь янгирын толгойтой, 4 нь адууны толгойтой, 4 нь араатан амьтны дүрстэй хоёр нь бугын толгойн дүрстэй (Баярсайхан 2017, 181-182; Баярсайхан 2021, 78-88). Эдгээрээс зөвхөн толтдоо бугын толгойн дүрстэй хоёр чинжаал байна. Үүний нэг нь Хиргисүүрийн дэнжийн 13 дугаар буган хөшөө (Волков 2002, 55), нөгөөх нь Уушигийн өврийн 15 дугаар буган хөшөө (Волков 2002, 193) юм. Эдгээр нь бидний шинээр баримтжуулан нийтлүүлж буй чинжаалтай ерөнхий хэлбэр, болон толт дээрх бугатай ерөнхийдөө адил юм (Зураг 3 А-В.). Эврийн хувьд Хиргисүүрийн дэнжийн буган хөшөөний чинжаалтай адил бөгөөд хоёр чих дүрсэлснээрээ өөр. Мөн нөгөө хоёр чинжаалын бариул хээгүй цулгүй бол бидний өгүүлэн буй чинжаалын бариулыг гоёмсог уулан хээгээр чимжээ. Эдгээр чинжаалууд бүгд хуйтай дүрслэгджээ. Мөн уг чинжаалыг бодит хэмжээгээр нь сийлсэн бололтой. Учир нь өдгөө Монголын үндэсний музейд хадгалагдаж буй толтдоо аргалын толгойн дүрстэй үзүүр хэсэг нь хугарсан хүрэл илд 44 см урт юм (Монголын үндэсний музей 2009, 31). Уг илдийн хугарсан үзүүр хэсгийг нөхөн сэргээж тооцвол ойролцоогоор 60 см орчим болно. Нэгэн үеийн энэхүү эх олдворын хэмжээтэй харьцуулан үзэхэд эл буган хөшөөн дээрх чинжаалын хэмжээ нь бодитоор дүрслэгдсэн байх боломжтой байна.

Үүнээс гадна уг хөшөөний бамбайн орой дээр дүрслэгдсэн шовгор сэртэн дүрслэл нь буган хөшөөний соёлд маш ховор бөгөөд зөвхөн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутаг Хөшөөтийн 2 дугаар буган хөшөөнд дүрслэгдсэн байдаг (Волков 2002, 209).

Ийнхүү эрин үеийн түүх өгүүлсэн нэгэн гайхамшигт дурсгал хувь заяаны нугачаанд анх байсан газраасаа зөөгдөж, тал хэсэг нь хугарч алга болсон ч цагийн цалгианд сүйдсэн нэгэн сүмийн туурь дээр өнөөг хүртэл цэхлэн зогсох ажгуу. Язгуур соёл, өв уламжлал, өвөг дээдсийн суу алдрыг дуурьсах эртний түүхэн дурсгалуудаа хайрлан хамгаалж, судлан сурталчилж, үнэ цэнийг нь өөрсдөө ухамсарлаж, үеийн үедээ үлдээн оршоох нь Монгол овогт хүн бүрийн ариун үүрэг мөн билээ.

НОМ ЗҮЙ

Эрдэнэ-Очир, Н., Батболд, Н., Баярсайхан, Ж., Батсүх, Д., Батбаяр, Т., Мөнхбаяр, Л., Даваахүү, Э., Маргад-Эрдэнэ, Г., Дашзэвэг, Б., Баярмаа, Р., Ариунзаяа, Б., Амина, Ж., Давидос, Ж. “Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай археологийн хайгуул судалгааны ажлын тайлан. I-III боть. Хян. Эрэгзэн, Г. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2025.

Баярсайхан, Ж. *Монголын умард нутгийн буган хөшөөд*. Улаанбаатар, 2017.

Баярсайхан, Ж. “Зүлэгтийн голын Жаргалантын үзүүрийн буган хөшөөд ба нэгэн бүтээлд өгөх эхний шүүмж”. *Нүүдэлчдийн өв судлал* 22, no. 6 (2021): 78–88.

Волков, В.В. *Оленные камни Монголии*. Улан-Батор, 1981.

Баярсайхан, Ж. “Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе.” *Монголын үндэсний музей*. Улаанбаатар, 2009.


Монголын Урлагийн Зөвлөл. 2025. “Монголын сүм хийдийн түүхэн товчоон, мэдээлэл-ярилцлага: Ярилцлага өгөгч Дамдинжав, дугаар L219.” *Монголын Сүм хийдийн түүхэн товчоон*. Хандсан 2025 оны 10 сарын 6. <https://mongoliantemples.org/oralhistorypdfs/L219.pdf>.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Хавсралт зураг




Зураг 1. Ооромбо гэгээний дээд хүрээний туурь болон буган хөшөө буй газрын байрлал (Дроны зургаас боловсруулсан, өндөршилийн зураг Ж.Амина)




Зураг 2. Баясгалант уулын буган хөшөөний гэрэл зураг (Урд талаас). Зохиогчийн гэрэл зураг



Зураг 3. Баясгалант уулын буган хөшөөний гар зураг. (Зохиогчийн гар зураг)



Зураг 4. А. Баясгалант уулын буган хөшөөн дээрх чинжаал. Б. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушигийн өврийн 15 дугаар буган хөшөөн дээрх чинжаал. В. Баянхонгор аймгийн Хиргисүүрийн дэнжийн 2 дугаар буган хөшөөн дээрх чинжаал. (А. Зохиогч; Б-В. В.В.Волков)



Зураг 5. Баясгалант уулын буган хөшөөний бамбайн дүрслэл